



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК-ИЙН 2023
ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР
БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Огноо: 2024 оны 03 дугаар сарын 13 өдөр

Өлзийт Экаунт Аудит ХХК

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 6-р дугаар хороо, 6-р хороолол, Г.Бумцэндийн гудамж,
65-1 тоот

E-mail: auditulziit@gmail.com

Утас: 70130460, 99109702, 88117655

АГУУЛГА

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДУГНЭЛТ

САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ХУУДАС

1

2

3-5

6

7

8

9

10-24

“ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК

КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ:
(ТУЗ)-ИЙН ГИШҮҮД:

Л.Тэмүүжин
С.Цэвэгмид
О.Баярмагнай

ТУЗ-ийн дарга
ТУЗ-ийн гишүүн
Хараат бус гишүүн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:

Д.МОНХБАТ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:

Үнэт цаасны зах зээл дээр зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх, Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй.

АЛБАН ХАЯГ:

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19-р байр 12 давхарт, 1214 тоот

ХАРИЛЦАГЧ БАНКУУД:

Төрийн сан
Чингис хаан банк
Төрийн банк
Хаан банк
Хас банк

АУДИТЫН БАГИЙН ГИШҮҮД:

“Өлзийт Экаунт Аудит” ХХК-ний аудитын баг



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК-д

ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК ХХК

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-19,
12 давхар, 1214 тоот. Утас: +(976) 77117977
Веб: <http://www.dbmamc.mn/>
И-мэйл: info@dbmamc.mn

2024.02.19 № 3/24

танай -ны № -т

Гүйцэтгэх удирдлагын батламж мэдэгдэл

“Ди Би Эм Ассет Менежмент УЦК” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мөнхбат, нягтлан бодогч Г.Түвшинзаяа бид энэ аудитлагдсан санхүүгийн тайланд хавсаргасан тус компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ээр дуусгавар болгосон жилийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон улсын Стандартын дагуу Монгол улсад мөрдөгдж байгаа хууль дүрэм журмыг баримтлан материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв илэрхийлсэн мөн Аудитын ажилд шаардлагатай бүхий л мэдээллээр хангаж ажилласан гэдгийг үүгээр баталж байна.



“Ди Би Эм Ассет менежмент УЦК”
ХХК-ийн нягтлан бодогч

Г.Түвшинзаяа



ӨЛЗИЙТ ЭКАУНТ АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ХЯНАЛТЫН ХАРААТ БУС ИТГЭМЖЛЭГДСЭН БАЙГУУЛЛАГА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН “ДИ БИ ЭМ АССЕТ МЕНЕЖМЕНТ УЦК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТАНАА

Санхүүгийн тайлангийн Аудитын тайлан

Дүгнэлт

Бид 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, тодруулгаас бүрдсэн “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн санхүүгийн тайланда аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдал, тухайн жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлалгналын Олон Улсын Стандартууд, Монгол улсад мөрдөгдөж байгаа хууль дүрэм журмын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн энэхүү аудитын ажилд Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн дагуух үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланда аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн ба асуудлуудын улмаас дүгнэлтээ хязгаарлаагүй.

Бидний мэргэжлийн үнэлэмжээр дараах асуудлыг аудитын гол асуудал гэж үзэж байна.

Тасралтгүй үйл ажиллагааны талаар

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХКомпани нь тайлант онд ХОС-ын тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагааны орлого олоогүй, тасралтгүй үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй байгаа боловч “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан” үүсгэн байгуулах бэлтгэл ажлыг хангаж, хөрөнгө оруулалтын сангийн бодлогын баримт бичгүүдийг шалгуурын дагуу боловсруулж байна. Тус хөрөнгө оруулалтын сангийн шийдвэрээр үүсгэн байгуулагдах бөгөөд хөрөнгө оруулах, үүсгэн байгуулах шийдвэр хүлээгдэж байна. Иймд бид байгууллагын тасралтгүй байх чадварын талаар ноцтой эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөлийн талаар тодорхойгүй байдал хараахан үүсээгүй байна гэж үзсэн.

Бидний гүйцэтгэсэн горим, сорил :

Бид удирдлагын баримталж буй бодлого, алсын харааг үнэлж хэрэгжүүлж буй төслийн талаар олж авсан ойлголтоо зохистой эсэхийг авч үзсэн.

Авлагын үлдэгдлийн талаар

- Сухбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2022 оны 02 сарын 09-ны өдрийн 181/ШШ2022/00145 тоот шүүхийн шийдвэрийн дагуу “Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК нь “Чингис хаан банк” ХХК-наас нийт 962,319.4 мянган төгрөгийн авлагыг төлүүлэхээр шийдвэрлэсэн боловч тайланда онд төлөлт хийгдээгүй.
- Түрээслэгч байгууллагатай холбоотой 34,247.8 мянган төгрөг, татан буулгах комисст ажилласан ажилтнаас авах 144,706.6 мянган төгрөгийн авлагаас тайлант онд 14,593.4 мянган төгрөгийн төлөлт хийгдсэн байна.

Бидний гүйцэтгэсэн горим, сорил :

Санхүүгийн тайланда бүртгэгдсэн авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулах, тооцооллын үнэн зөвийг үнэлэх, горим сорилыг гүйцэтгэсэн.

Бусад мэдээлэл

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно. Хэрэв бид аудитын тайлангийн өдрөөс өмнө олж авсан бусад мэдээлэлд хийсэн өөрсдийн ажилд үндэслэн бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэл агуулсан байна гэж дүгнэвэл энэ тухайгаа тайлагнах шаардлагатай.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 10/22 дугаар тогтоолын дагуу “Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ байгуулан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй жилийн 10 хувийн хүйтэй, 68,100 ширхэг үнэт цаасыг нийт 6,810,000,000 төгрөгөөр худалдан авч бусад санхүүгийн хөрөнгө дансанд бүртгэсэн байна.

Тайлант онд Суутган төлөгчийн аж ахуйн нэгжид олгосон орлогод ногдуулан суутгасан албан татварын тайланда Монгол Улсаас байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсад олсон орлогод ногдуулсан татварт 721,491.4 мянган төгрөгийн орлогоос 144,298.3 мянган төгрөгийн татвар төлөхөөр тайлагнаж, тайлант онд 130,317.3 мянган төгрөг төлсөн байна. Бид өөрсдийн үндэлэмж тооцоолол, олж авсан мэдлэг, нотлох баримтдаа үндэслэн энэхүү татварын асуудлыг цаашид судлан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК-ийн санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналтыг Нягтлан бodoх бүртгэлийн тухай хуулийн 19-р зүйлд заасан шалгуур үзүүлэлтэд нийцэж буй эсэхийг шалгасан.

Компанийн удирдлага нь тус хуулийн шаардлагыг биелүүлэх, санхүүгийн тайлагналын дотоод хяналтыг үр дүнтэй байлагах, санхүүгийн тайлангийн дотоод хяналтын үр нөлөөг үнэлэх үүрэгтэй.

Бидний үүрэг бол аудитын үндсэн дээр санхүүгийн тайлагналын талаарх компанийн дотоод хяналтын талаар дүгнэлт гаргах юм.

Бид аудитаа АОУС-ын дагуу хийсэн. Эдгээр стандартууд нь бид санхүүгийн тайлангийн үр ашигтай дотоод хяналтыг бүх материаллаг зүйлсийн хувьд хангасан эсэхэд үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаардлаг Бидний сорилтой

Эрсдэлийг үнэлэх, үнэлэгдсэн эрсдэлд үндэслэн дотоод хяналтын загвар, үйл ажиллагааны үр нөлөөг хянах, үнэлэх, шаардлагатай гэж үзсэн бусад процедурыг хэрэгжүүлэх зэрэг багтсан. Бидний хийсэн аудит бидний дүгнэлт гаргах үндэслэлтэй гэж үзэж байна.

Санхүүгийн тайлагналын талаарх дотоод хяналт нь санхүүгийн тайлангийн найдвартай байдал, санхүүгийн тайланг гадны хэрэглэгчдэд зориулан үнэн зөв бэлтгэх хяналтыг ТУЗ болон түүнээс томилогдсон гүйцэтгэх удирдлагын хэрэгжүүлэх үйл явц юм.

Бидний дүгнэлтээр, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19-р зүйлд заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг компанийн удирдлага тогтоосон ба 2023 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар энэхүү дотоод хяналтын дүрэм, журмаар тогтоосон процедурын дагуу санхүүгийн тайлангийн үр дүнтэй дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Компанийн үүрэг хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын дагуу эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн заилиан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналагүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага компанийн санхүүгийн тайланг гаргах болон үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах чадамжтай байх үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын явцад тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлан гэсэн ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь заилиан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцдог.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр зүйлд зааснаар хувьцаа эзэмшигчийн хүсэлтийн дагуу хийгдэж аливаа өөр зорилго агуулаагүй.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн аудитын баг тайланг бэлтгэлээ.

“Өлзийт экаунт аудит” ХХК-ийн

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭЖАВ

Огноо: 2024 оны 03 дугаар сарын 13 өдөр

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, 6-р хороолол, Г.Бумцэндийн гудамж,
65-р байрны баруун талын өргөтгөл 1 тоот

Утас: 70130460, 99109702, 88117655



"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН
2023 оны 12 сарын 31 өдөр

(төгрөгөөр)

Тод	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	4.1	2,163,134,396.10
Дансны авлага		1,302,447,115.79
Татвар,НДШ-ийн авлага	4.3	14,351,765.82
Бусад авлага	4.2	1,055,265,860.47
Бусад санхүүгийн хөрөнгө	4.4	7,160,000,000.00
Бараа материал	4.5	7,460,000,000.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо		36,363.64
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө /Борлуулах бүлэг хөрөнгө /		10,392,919,931.48
		9,949,292,794.09
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	4.6	97,128,719.08
Биет бус хөрөнгө		555,376.94
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		97,684,096.02
		85,670,110.25
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	4.7	1,464,799,032.8
Цалингийн өглөг		734,971,183.25
Татварын өр		
НДШ-ийн өглөг	4.8	122,000.0
Бусад богино хугацаат өр төлбөр		14,049,391.88
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		15,909.23
		1,464,921,032.84
		749,036,484.36
Эзэмшигчдийн өмч		
Төрийн өмч	4.9	10,000,000,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		10,000,000,000.00
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг	4.10	(974,317,005.34)
Эзэмшигчдийн өмчийн дүн		(714,073,580.02)
		9,025,682,994.66
		9,285,926,419.98
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		
		10,490,604,027.50
		10,034,962,904.34

Аудитор *Ч.Эрдэнэжав* Ч.Эрдэнэжав

"Ди Би Эм асset менежмент УЦК" ХХК
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2023 оны 12 сарын 31 өдөр

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тод	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
Үйл ажиллагааны орлого /Цэвэр/			
Брокер, дилерийн үйл ажиллагааны орлого			
Андеррайтерийн үйл ажиллагааны орлого			
Үнэт цаасны арилжааны цэвэр орлого			
Үнэт цаасны үнэлгээний тэгшигтгэлийн цэвэр орлого			
Нийт ашиг (алдагдал)			
Түрээсийн орлого			
Хүүний орлого	4.11	150,054,794.51	782,832,893.93
Ногдол ашгийн орлого			
Хувьцааны ногдол ашиг			
Хараат болон хамтарсан компаниас олсон ашиг			
Бусад орлого	4.13	687,260.00	31,154,510.00
Борлуулалт, маркетингийн зардал			
Ерөнхий ба удирдлагын зардал	4.12	354,401,385.98	326,865,923.21
Санхүүгийн зардал			
Бусад зардал	4.14	383,103,498.87	145,822,768.45
Гадаад валютын ханшын зөрүүний олз (гарз)			
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)			
Хөрөнгө орууулалт борлуулснаас үүссэн олз (гарз)			
Бусад ашиг (алдагдал)			
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)			
Орлогын татварын зардал	4.15	<u>586,762,830.34</u>	<u>341,298,712.27</u>
Татварын дараах ашиг (алдагдал)			
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			
Бусад дэлгэрэнгүй орлого			
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү			
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү			
Бусад олз (гарз)			
Орлогын нийт дүн			
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)			
		<u>601,768,309.80</u>	<u>263,015,422.94</u>


Аудитор

Ч.Эрдэнэжав

"Ди Би Эм асset менежмент УЦК" ХХК
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
2023 оны 12 сарын 31 өдөр

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан Ашиг	Өмчийн дүн
	Тод 4.9			Тод 4.10.	
2021 оны 12 -р сарын 31-ээрх үлдэгдэл	10,000,000,000.00			(372,548,695.54)	9,627,451,304.46
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00			(372,548,695.54)	9,627,451,304.46
Бусад дэлгэрэнгүй орлого Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг					
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал				(601,768,309.80)	(601,768,309.80)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,000,000,000.00			(974,317,005.34)	9,025,682,994.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(2,771,997.62)	(2,771,997.62)
Залруулсан үлдэгдэл	10,000,000,000.00			(977,089,002.96)	9,022,910,997.04
Тайлант үеийн цэвэр ашиг				263,015,422.94	263,015,422.94
Бусад дэлгэрэнгүй орлого Өмчид гарсан өөрчлөлт Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					
2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	10,000,000,000.00			(714,073,580.02)	9,285,926,419.98

Аудитор  Ч.Эрдэнэжав

"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК
МОНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2023 оны 12 сарын 31 өдөр

(төгрөгөөр)

То д	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
---------	---------------------------	---------------------------

ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ
Мөнгөний орлогын дүн

Бараа борлуулсаны, үйлчилгээ үзүүлсний орлого
 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого
 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө
 Буцаан авсан албан татвар

Бусад мөнгөн орлого

Мөнгөн зарлагын дүн

Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн
 Ажиллагчдад төлсөн мөнгө
 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө
 Бараа материал худалдан авахад төлсөн
 Ашиглалтын зардалд төлсөн
 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө
 Татварын байгууллагад төлсөн
 Даатгалын төлбөрт төлсон
 Зохицуулалтын хөлс, шимтгэл, хураамжинд төлсөн
 Бусад мөнгөн зарлага

Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
МӨНГӨН ГҮЙЛГЭЭ**

Мөнгөн орлогын дүн

Үндсэн хөрөнгө борлуулсны орлого
 Биет бус хөрөнгө борлуулсны орлого
 Бусдад олгосон зээл болон урьдчилгааны буцаан төлөлт
 Хүлээн авсан хүүгийн орлого

Мөнгөн зарлагын дүн

Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн
 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн
 Бусад ургацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн
 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа
 Бусад

Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээний дүн

САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ

Мөнгөн орлогын дүн

Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан
 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан

Мөнгөний зарлагын дүн

Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө
 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн

Санхүүгийн мөнгөн гүйлгээний дүн

Валютын ханшийн зөрүү

Бүх цэвэр мөнгөн гүйлгээ

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл

10,216,188.67	595,201,262.73
---------------	----------------

9,605,506.85	595,201,262.73
--------------	----------------

1,447,027,375.42	1,274,831,269.63
-------------------------	-------------------------

349,264,328.66	370,789,551.35
----------------	----------------

95,756,027.12	96,825,260.87
---------------	---------------

1,674,450.00	7,762,935.00
--------------	--------------

97,069,683.04	6,894,975.60
---------------	--------------

4,971,226.42	490,000.00
--------------	------------

239,588,614.11	162,073,868.17
----------------	----------------

1,509,590.00	
--------------	--

657,193,456.07	629,994,678.64
----------------	----------------

(1,436,811,186.75)	(679,630,006.90)
---------------------------	-------------------------

787,664,385.71	472,440,482.19
----------------	----------------

588,968,221.33	305,609,910.96
----------------	----------------

48,696,164.38	61,948,379.45
---------------	---------------

150,000,000.00	104,882,191.78
----------------	----------------

7,600,000,000.00	650,000,000.00
-------------------------	-----------------------

7,100,000,000.00	
------------------	--

500,000,000.00	650,000,000.00
----------------	----------------

(6,812,335,614.29)	(177,559,517.81)
---------------------------	-------------------------

ТОДРУУЛГА 1 – Товч танилцуулга

1.1 Компанийн тухай

"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК

Регистр: 6229697

(Аж ахуйн нэгжийн нэр)

Улсын бүртгэлийн дугаар: 9011659117

Захирал: Д.Мөнхбат

Утас: 99998350

Цахим шуудан: munkhbat@dbmc.mn

Нягтлан бодогч: Г.Түвшинзаяа

Утас: 89105500

Цахим шуудан: tuvshinzaya@dbmc.mn

Өмчийн хэлбэр:

Монгол Улсын Хөгжлийн банк 100 хувь эзэмшдэг.

Албан ёсны хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 -р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 19-р байр, 12 давхар 1214 тоот.

Харилцаг санхүү, татварын байгууллага:

Сүхбаатар дүүргийн санхүү, татварын байгууллагатай харилцаг.

1.2 Үйл ажиллагааны чиглэл:

Байгууллага нь анх 2017 оны 08 дугаар сарын 28-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн. Монголын хөрөнгийн зах зээлд зохицуулалттай ажиллагаа эрхлэх 380/16 тоот тусгай зөвшөөрлийн гэрчилгээ эзэмшдэг.

"Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх", Хөрөнгө оруулалтын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 407 дугаар тогтоолыг үндэслэн үүсгэн байгуулагдсан.

Бид аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж буй аудитын хууль тогтоомжийг баримтлан ажилласан. Аудитын дүгнэлт гаргахдаа тус компаниас бидэнд танилцуулсан санхүүгийн баримт, материалд үндэслэсэн болно. Аудитын явцад бидэнд танилцуулаагүй аливаа баримт материалыаас үүсэх хариуцлагыг манай компани хүлээхгүй юм.

1.3 Байгууллагын товч танилцуулга

"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК-ийг Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 407 дугаар тогтоолыг үндэслэн үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 155 тоот тогтоолоор компанийг татан буулгах шийдвэр гарч, татан буулгах комисс байгуулагдан ажилласан 2021 оны 252 тоот тогтоолоор татан буулгах үйл ажиллагааг зогсоон, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэх шийдвэр гарсан.

Тус шийдвэрийг хэрэгжүүлэн Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны 29 дүгээр тогтоолоор компанийн дүрэм болон бутцийг шинэчлэн баталсан.

Тус компани нь Азийн хөгжлийн банк болон Улаанбаатар хотын захиргаатай хамтран "Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчлэл" төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

ТОДРУУЛГА 2 – НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

2.1 Мөрдсөн стандарт

2023 оны 12 дугаар сарын 31 өдрийн Компанийн санхүүгийн тайлангуудыг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын /СТОУС/ дагуу бэлтгэж тайлagnаж баталгаажуулсан.

2.2 Тайлан бэлтгэх үндэслэл

Санхүүгийн тайлан бэлтгэх зорилго нь байгууллагын хөрөнгө, эх үүсвэр, санхүүгийн байдал, хүлээн зөвшөөрсөн орлого, зарлага, тэдгээрийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв мэдээллээр хангаж, Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу илэрхийлэх явдал юм. Санхүүгийн тайлангууд нь НББОУСЗ-өөс гаргасан СТОУС –ын дагуу бэлтгэгдсэн. Санхүүгийн тайлангуудыг аккруэл сууриар, түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн, ажил гүйлгээг давхар бичилтийн аргаар бүртгэсэн бөгөөд Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгтээр төгрөгөөр санхүүгийн тайланг илэрхийлсэн.

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээг хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлгээ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт болон бүртгэсэн хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Бодит үр дүн нь эдгээр таамаглал, тооцооллоос ялгаатай байж болно.

2.3 Үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадвар

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд тулгуурлан бэлтгэгдсэн. НББОУС 1-ийн 25-д “ Санхүүгийн тайлан бэлтгэхдээ удирдлага нь үйл ажиллагаагаа тасралтгүй байдлаар үргэлжлүүлэн явуулах уг аж ахуйн нэгжийн чадвар боломжийг үнэлэх хэрэгтэй” гэж заасны дагуу одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүгийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадвар зэрэг өргөн хүрээний асуудлуудыг авч үзнэ. Компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадвар нь ирээдүйн ашигтай үйл ажиллагаа, зэрэг мөнгөн урсгалаас голчлон хамаарна.

“Ди Би Эм ассет менежмент УЦК” ХХК нь тайлант онд ХОС-ын тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагааны орлого олоогүй, тасралтгүй үйл ажиллагаа хангалтгүй харагдаж байгаа боловч “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан” үүсгэн байгуулах бэлтгэл ажлыг хангаж сангийн бодлогын баримт бичгүүдийг шалгуурын дагуу боловсруулж Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр үүсгэн байгууллагдах шийдвэрээ хүлээж байна. Иймд бид байгууллагын тасралтгүй байх чадварын талаар ноцтой эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөлийн талаар тодорхойгүй байдал хараахан үүсээгүй байна гэж үзсэн.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлогод орсон өөрчлөлтүүд

Нэмэлт өөрчлөлт орсон стандартууд

2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС-уудаас бусад нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил болно:

СТОУС 17 Нэмэлт өөрчлөлт жилийн
сайжруулалт

Даатгалын гэрээ,

НББОУС 1 Нэмэлт өөрчлөлт жилийн
сайжруулалт

Богино урт хугацаат өр төлбөрийн
ангилал

Үүнтэй холбоотой тодруулгыг Компанийн тайлант болон өмнөх оны мэдээллүүдийг харьцуулах зорилгоор толилуулав.

2.5 Нягтлан бodoх бүртгэлийн гол бодлогуудын товчоо

Эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн ангилал

Компани нь санхүүгийн тайландаа хөрөнгийг эргэлтийн ба эргэлтийн бус, өр төлбөрийг урт ба богино хугацаат гэж ангилдаг.

Өр төлбөр нь дараах тохиолдуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

Гадаад валютын хөрвүүлэлт

Компани нь санхүүгийн тайлангаа мөнгөн нэгж болох монгол төгрөгөөр гаргадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж Мөнгөн зүйлсийн төлөгдөх эсвэл хөрвүүлэх үед үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэнэ.

Тухайн тайлант хугацааны эцэст гадаад валютын ханш дараах байдалтай байсан.

Валют	2022 оны 12 дугаар сарын	2023 оны 12 дугаар сарын 31-
	31-ний ханш	ний ханш
Нэгж ам.доллар	3,444.60 төгрөг	3,410.69 төгрөг

2.5 Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс болон банкин дахь төгрөг, ам.доллар болон европийн харилцах данс дахь мөнгөнөөс бүрдэнэ.

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг, хөрөвхөө чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат өр төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдрэг, мөнгөний тодорхой дунд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

2.6 Санхүүгийн хэрэглүүр

Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дахь гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт

Санхүүгийн хувьд чухал бүрэлдэхүүн хэсэг агуулаагүй дансны авлага болон СТОУС 15 “Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого”-ын дагуу ажил гүйлгээний үнээр бүртгэхээс бусад бүх санхүүгийн хөрөнгийг ажил гүйлгээний зардлыг тохируулсан бодит үнэ цэнээр хэмжинэ.

Хайджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БУЦБДО)
- Бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БУЦАА)

Тайлант онд компанийд БУЦБДО-оор ангилагдах санхүүгийн хөрөнгө байхгүй байна. Ангиллыг тодорхойлоходоо:

- Санхүүгийн хөрөнгийг зохицуулах бизнесийн загвар
- Санхүүгийн хөрөнгийн гэрээлсэн мөнгөн урсгалын шинж чанарыг тус тус харгалзан үзнэ.

Санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого болон зардал нь санхүүгийн зардал, санхүүгийн олз болон бусад санхүүгийн зүйлсээр орлого болон зардалд хүлээн зөвшөөрөгдөх ба харин дансны авлагын үнэ цэнгийн бууралтыг бусад зардлаар хүлээн зөвшөөрнэ.

Санхүүгийн хөрөнгийн дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өргөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өргөөр хэмжинэ (БУЦАА-аар ангилагдаагүй үед):

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал “цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг” бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн
- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь “зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр” (SPPI) байвал

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өргөөс үнэ цэнгийн бууралтын хасагдуулагыг хассан дүнгээр хэмжинэ. Хүүг үр ашигт хүүгийн аргаар тооцоолно. Анхны үнэ цэнгийн бууралтын хасагдуулаг болон дараа үеийн өөрчлөлтүүдийг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнэ.

Бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө (БУЦАА)

Хорогдуулсан өргөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх ангиллын шаардлагад нийцэхгүй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэнэ.

Мөн тодорхой тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэхээр тогтох болно. Тухайлбал, компани дараа үед хорогдуулсан өргөөр хэмжих эсвэл бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх сонголт хийж болно.

Ийм сонголтыг зөвхөн нягтлан бодох бүртгэлийн зерүүтэй байдлыг арилгах эсвэл ихээхэн хэмжээгээр бууруулж байгаа тохиолдолд хийнэ.

Дээрх сонголтыг бүх ижил төстэй ажил гүйлгээнд мөрдэх шаардлагагүй. Харин энэ нь илүү мэдээлэл бий болгож байгаа тохиолдолд компани сонгож болох хувилбар юм.

Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлэх санхүүгийн хөрөнгө (БУЦБДО)

Дараах хоёр нөхцөл биелсэн тохиолдолд санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод илэрхийлнэ:

- Тухайн санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгал “цуглуулах ба борлуулах зорилгоор санхүүгийн хөрөнгө эзэмшдэг” бизнесийн загварын хүрээнд эзэмшиж байгаа бол, мөн

- Тухайн санхүүгийн хөрөнгийн мөнгөн урсгал нь "зөвхөн үндсэн ба хүүгийн төлбөр" (SPP) байвал.

Хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх үед бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөгдсөн олз, гарзыг ашиг, алдагдалд дахин ангилна.

2.7 Бусад санхүүгийн хөрөнгө

Компани нь дансны болон бусад авлагын авлага, гэрээний хөрөнгийг хялбаршуулсан аргаар нягтлан бодох бүртгэлд тусгадаг бөгөөд алдагдлын нөөцийг хүлээгдэж буй алдагдлын аргаар бүртгэдэг. Эдгээр нь санхүүгийн хэрэгслийн ашиглалтын хугацааны аль ч үед дефолт болох магадлалыг харгалzan үзсэн гэрээний мөнгөн урсгалын хүлээгдэж буй дутагдал юм. Нөөцийн матрицыг ашиглан хүлээгдэж буй алдагдлыг тооцоолоходо Компани нь өөрийн түүхэн туршлага, гадаад хүчин зүйлс, ирээдүйд чиглэсэн мэдээллийг ашигладаг.

Санхүүгийн өр төлбөрийн ангилал болон хэмжилт

Компанийн санхүүгийн өр төлбөрт дансны болон өглөг, үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд орно.

Санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-с өөрөөр хэмжих үед ажил гүйлгээний үнэ цэнийг тохируулсан бодит үнэ цэнээр нь хэмждэг.

Дараа үед санхүүгийн өр төлбөрийг БҮЦАА-р тодорхойлсон санхүүгийн өр төлбөр болон деривативаас бусад тохиолдолд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдсон өртгөөр хэмжинэ. Бодит үнэ цэнгийн олз гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Бүх хүйтэй холбоотой зардал болон санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнгийн өөрчлөлтийг санхүүгийн зардал эсвэл санхүүгийн орлогоор хүлээн зөвшөөрнө.

Бусад санхүүгийн бус хөрөнгө

Компани нь бусад санхүүгийн бус хөрөнгөд тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл анgid хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Иймд терлийн зардуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ. Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

2.8 Үндсэн хөрөнгө

Хөрөнгийг борлуулах болон данснаас хасах үед тухайн хөрөнгийн өртөг, хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын дүнг оролцуулан данснаас хасах бөгөөд үүнээс үүсэх аливаа олз, гарзыг тайлант жилийн орлого, үр дүнгийн хэсэгт бүртгэнэ.

Элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тэдгээрийн өртгийг доорх хүлээгдэж буй ашиглах хугацааны туршид шулуун шугамын аргыг ашиглан үлдэх өртөг хүртэл нь бууруулан хуваарилж тооцно:

Ангилал	Жил
Барилга	25
Тоног төхөөрөмж	10
Тавилга, эд хогшил	10
Тээврийн хэрэгсэл	10

Компьютер, техник
хэрэгсэл

3

Биет бус хөрөнгө (үргэлжлэл)

Компанийн биет бус хөрөнгө нь компьютерын программ хангамжийн лицензүүд байх бөгөөд хүлээгдэж буй гурваас (3) арван (10) жилийн хугацаанд шулуун шугамын аргыг ашиглан хорогдуулна.

Компанийн худалдан авсан тодорхой ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг түүний өртгөөс хуриатлуулан хорогдуулга болон үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр дүнгээр хэмждэг.

Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Үнэ цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илрэх үед болон хөрөнгийн (бараа материал болон санхүүгийн хөрөнгөөс бусад) бүртгэлийн дүнгүүд үнэ цэнийн бууралт агуулж буй эсэхийг шалгах шаардлагатай болсон тохиолдолд хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолно.

Бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг.

2.9 Бараа материал

Бараа материалыг өртөг цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар бүртгэнэ. Бараа материалыг өнөөгийн байршил болон нөхцөлд авчрахад гарсан материал, дагалдах зүйлсийн үнэ өртөгт орох ба тэдгээрийн жигнэсэн дундаж өртгөөр бараа материалын өртгийг тодорхойлно. Цэвэр боломжит үнэ цэнэ нь бизнесийн хэвийн нөхцөлд тооцоолсон борлуулалтын үнээс уг борлуулалтын тооцоолсон зардлыг хассан дүн болно

Бараа материалын үнэ цэнэ бууралт

Гэмтсэн, биетээр муудсан, хуучирсан, худалдан борлуулах үнийн түвшин өөрчлөгдсөн ба бусад шалтгаанаар бараа материалын цэвэр боломжит үнэ цэнэ өртгөөсөө бага болсон үед Компани нь бараа материалын өртгийг бууруулж бичнэ. Бараа материалын өртөг, цэвэр боломжит үнэ цэнэ хоёрын аль багаар үнэлэх үнэлгээг байнгын үзлэг шалгалтаар санхүүгийн бүртгэлд бодитой үнэлэн бүртгэнэ. Хуучирсан ба ашиглагдахгүй нь тогтоогдсон бараа материалыг мөн акталж тухайн санхүүгийн жилд зардал болгоно.

Урьдчилгаа

Урьдчилгаа нь төлбөр хийгдсэн боловч бодитоор гаралаагүй байгаа зардлыг харуулна. Урьдчилгааны холбогдох бараа материал болон үйлчилгээг нэг жилийн дотор авахаар байгаа бол уг урьдчилгааг санхүү байдлын тайланд эргэлтийн хөрөнгөөр ангилна. Бусад тохиолдолд урьдчилгааг эргэлтийн бус хөрөнгөөр ангилна.

2.10 Орлого хүлээн зөвшөөрөх

Орлогын эдийн засгийн үр өгөөж нь Компанид орох нь тодорхой болсон болон найдвартайгаар хэмжих боломжтой болсон хэр хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Орлогыг хүлээн авсан зүйлийн бодит үнэ цэнээс хөнгөлөлт, буцаалт, борлуулалтын татвар эсвэл хураамжийг хассан дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Борлуулсан барааны болон үйлчилгээний өртөг

Борлуулсан барааны өртөг нь тухайн барааны эрсдэл нь худалдан авагч талд

Борлуулсан барааны орлого нь барааны оронд хүлээн авсан болон хүлээн авах авлагаас буцаалт болон хөнгөлөлт мөн хямдрал болон их хэмжээний худалдан авалтын урамшууллыг хассан бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

Түрээсийн орлого

Түрээсийн орлого нь үйл ажиллагааны түрээсийн нөхцөлийн дагуу шулуун шугамын аргаар хүлээн зөвшөөрөгддөг ба тайлант хугацаанд түрээсийн орлого олоогүй.

Хүүгийн орлого

Хүүгийн орлогыг бүртгэхдээ үр ашигт хүүгийн арга ашиглан бүртгэнэ. Үр ашигт хүүгийн хувь нь ирээдүйд хүлээгдэж буй орох, гарах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэгслийн эргэн төлбөр хийх хугацаа ба түүнээс богино хугацааны туршид дискаунтлаж санхүүгийн хэрэгслийн бүртгэлийн цэвэр дүнг бодитойгоор тооцох хүү юм.

Бусад орлого

Бусад орлого ба олз гэдэг нь мэргэжлийн байгууллагын байнгын бус гэнэтийн ажил гүйлгээнээс түүнчлэн хувь нийлүүлэгчдийн орлого, хөрөнгө оруулалтаас бусад тухайн тайлант хугацаанд мэргэжлийн байгууллагад нөлөөлөх бүх ажил гүйлгээ, үйл явдлын дунд өмчид гарсан цэвэр өсөлтийг бүртгэсэн.

2.11 Зардлууд

Ерөнхий болон удирдлагын зардал, борлуулсан барааны өртөг, бусад зардал, санхүүгийн зардлыг гарсан үед нь дэлгэрэнгүй орлогын тайландаа хүлээн зөвшөөрнө.

Борлуулсан барааны өртөг болон зардал

Борлуулсан барааны өртөг болон зардал нь тухайн зардал гарсан тайлант хугацаанд орлого зардлаар хүлээн зөвшөөрөгднө.

Түрээс

Тухайн гэрээ нь түрээсийн эсвэл түрээс агуулж байгаа эсэхийг тодорхойлоходоо гэрээний агуулгад үндэслэх ба гэрээг гүйцэтгэхэд тусгай хөрөнгийг ашиглах шаардлагатай эсэх болон гэрээ нь хөрөнгийг ашиглах эрхийг шилжүүлж байгаа эсэх зэргийг үнэлж үзэх шаардлагатай.

Компани нь түрээслэгч үед үйл ажиллагааны түрээсийн төлбөрийг түрээсийн хугацаанд шулуун шугамын аргаар бодож дэлгэрэнгүй орлогын тайландаа зардлаар бүртгэнэ.

Тайлант хугацааны орлогын албан татвар

Компани нь Монгол Улсын Засгийн газрын дүрэм журмын дагуу татвар ногдох орлогыг нэмэгдүүлэхгүй орлого болон татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын зүйлсээр залруулсан, санхүүгийн тайлагналын зорилгоор тодорхойлсон өөрийн орлогоос тайлан тэнцлийн өдрийн байдаар хучин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээгээр бодож өөрийн орлогын албан татварын хэмжээг тодорхойлдог.

Хойшлуулсан албан татвар

Хойшлогдсон татварын өр төлбөр нь түр зөрүүнд хүлээнд зөвшөөрөгднө. Хойшлогдсон албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө.

2.12 Эздийн өмч

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгийн ангилалд оруулна. Шинэ хувьцаа гаргахтай шууд холбоотой нэмэлт зардлыг хувьцаа борлуулсны татварын дараах орлогоос хасах дүнгээр эздийн өмчид тусгадаг. Компани нь тайлант онд шинээр хувьцаа гаргаагүй, хувьцааны тоо ширхэгт өөрчлөлт ороогүй болно.

2.13 Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг, алдагдал нь хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлаас зарласан ногдол ашгийг хассан дүнг илэрхийлнэ.

Болзошгүй үйл явдлууд

Санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөрүүдийг хүлээн зөвшөөрдөггүй. Эдийн засгийн үр өгөөж агуулсан эх үүсвэр гадагшаа урсах боломжгүй биш л бол эдгээр өр төлбөрийн талаар нэгтгэсэн санхүүгийн тайланд тодруулга хийж өгнө. Нэгтгэсэн санхүүгийн тайланд болзошгүй хөрөнгүүдийг хүлээн зөвшөөрдөггүй гэхдээ эдийн засгийн өгөөж орж ирэх нь магадлалтай болсон үед санхүүгийн тайланд тодруулга хийнэ.

Тайлант хугацааны дараах үйл явдал

Тайлант хугацааны эцэс дэх Компанийн санхүүгийн байдлын талаар нэмэлт мэдээллийг хангаж өгөх тайлант хугацааны дараах үйл явдлууд (залруулах үйл явдлууд) – ыг санхүүгийн тайлангуудад тусгана. Залруулга шаардахгүй, материаллаг хэмжээтэй, тайлант хугацааны дараах үйл явдлуудыг санхүүгийн тайланд тодруулж өгнө.

Холбоотой талууд

Санхүүгийн тайлангийн зорилгоор, хуульд заасан шаардлагуудыг хангасан үед тухайн тал нь Компанийн холбоотой талд тооцогдоно.

Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойрын гишүүнийг дараах тохиолдолд компанийтай холбоотой гэж үзнэ.

Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группийн бүрэлдэхүүнд багтаж байвал /өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанийд хамаардаг охин компани бүгд бусадтай холбоотой/

Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;

2.14 Капиталын удирдлагын бодлого, журам

Компанийн капиталын удирдлагын бодлогын зорилго цаашид үйл ажиллагаа тасралтгүй явуулах чадавхыг хангах, холбогдох эрсдэлийн түвшнийг үндэслэн тэдгээрийн үнийг оновчтой тогтоо замаар хувьцаа эзэмшигчдэд зохистой өгөөжийг хүртээх юм.

Санхүүгийн хараат байдлаас зайлсхийг үр ашигтай санхүүгийн бүтцийг бий болгохын тулд удирдлага Компанийн капиталын шаардлагыг үнэлнэ. Компани капиталын бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, хөрөнгийн эрсдэлийн шинж чанарыг харгалзан тохируулга хийдэг.

Компанийн тайлант хугацааны капиталын дүнг доор хураангуйлан харуулав. Удирдлага нь өр төлбөр болон өмчийг оновчтой зохицуулах замаар хувьцаа эзэмшигчдэд бий болох өгөөжийн түвшин хамгийн их хэмжээнд байлагах, байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах байдлаар капиталаа удирддаг.

	<u>2022</u>	<u>2023</u>
Нийт өр төлбөр	1,464,921,032.84	749,036,484.36
Нийт өмч	9,025,682,994.66	9,275,353,505.25
Өрийн харьцаа	16%	8%

2.15 Бодит үнэ цэнийн хэмжилт

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг санхүүгийн тайланд бодит үнэ цэнийн шатлааар түрван түвшинд ангилна. Эдгээр түрван ангиллыг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан орцуудын ач холбогдолд үндэслэнэ.

Удирдлага нь санхүүгийн хэрэглүүрийг ангилахдаа бодит үнэ цэнийн түвшнийг ашигладаг. Дараах хүснэгтээр бодит үнэ цэнийг хэмжсэн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийн шатлалыг түвшин тус бүрээр 2023 оны 12 сарын 31-ны байдлаар харуулав. Үүнд:

Утга	2022		2023	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ
Хорогдуулсан өргөөр бүртгэсэн хөрөнгүүд				
Дансны болон бусад авлага	1,169,307,702.11	1,169,307,702.11		1,169,307,702.11
Бусад санхүүгийн хөрөнгө	7,160,000,000.00	7,160,000,000.00	7,460,000,000.00	7,460,000,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	2,163,134,396.10	2,163,134,396.10		
Дүн	10,589,523,344.78	10,378,400,256.57	7,460,000,000.00	8,629,307,702.11
Хорогдуулсан өргөөр бүртгэгдсэн өр төлбөрүүд				
Дансны болон бусад өр төлбөр	1,464,799,032.84	1,464,799,032.84	749,036,484.36	749,036,484.36
Дүн	1,464,799,032.84	1,464,799,032.84	749,036,484.36	749,036,484.36

2.16 Тайллагналын үеийн дараах үйл явдал

Тайлант хугацааны эцсээс хойш компанийн санхүүгийн тайланд тодруулагдах буюу залруулагдах материаллаг зүйлс ажиллагаагүй болно.

2.17 Болзошгүй өр төлбөр

Компани 2023 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар болзошгүй хөрөнгө, өр төлбөр үүсгэх нөхцөл байдал байхгүй болно. Өөрөөр хэлбэл байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэхүйц болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлага байхгүй болно.

3. Санхүүгийн хэрэглүүрийн эрсдэл

Санхүүгийн үндсэн хэрэгслүүд нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага ба бусад авлага, дансны ба бусад өглөг болон зээлээс бүрддэг.

Хүлээн зөвшөөрөх шалгуур, орлого зарлагыг хүлээн зөвшөөрөх үндэслэл, санхүүгийн хөрөнгө, өр, төлбөр, эздийн өмчийн хэрэглүүрийн ангиллын талаар хэрэглэж буй нягтлан бодох бүртглийн үндсэн бодлого, арга зэргийг тодруулгад дэлгэрэнгүй харуулсан болно. Компани нь санхүүгийн хэрэглүүрийн идэвхтэй арилжаанд оролцдоггүй. Компанийн өртөж болох томоохон санхүүгийн эрсдэл нь доорх байдалтай байна.

3.1 Зах зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг байна. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын зорилго нь өгөөжийг оновчтой байлгах зуур зах зээлийн эрсдэлийг хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд удирдаж, хянах явдал болно.

3.2 Гадаад валютын эрсдэл

Компанийн тайлагналын валют болох үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөс бусад валютаар хийгдсэн борлуулалт, худалдан авалт болон зээл нь гадаад валютын ханшийн эрсдэлийг хүлээж байдаг.

Компани нь гадаад валютаар зарим гүйлгээг хийдэг. Иймээс гадаад валютын ханшийн өөрчлөлтийн эрсдэлд өртдөг байна. Компанийн ихэнх гүйлгээ Монгол төгрөгөөр хийгддэг.

	2022 /доллар/	2023 /доллар/	2022 /төгрөг/	2023 /төгрөг/
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	425,239.66	215,485.63	1,464,780,532.84	734,954,683.38
Дансны болон бусад авлага				
Дансны болон бусад өглөг	(425,239.66)	(215,485.63)	(1,464,780,532.84)	(734,954,683.38)
	0.00	0.00	0.00	0.00

3.3 Дансны болон бусад авлага

Компани үйлчлүүлэгчдийн авлагуудыг төлөгдөх боломжтой авлага гэж үзэн хугацаа хэтэрсэн авлагын дунд үнэ цэнийн бууралтын нөөц байгуулсан байна. Тайлант онд 144,347,904.45 төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга нэмж тооцсон байна. Чингис хаан банкнаас авах 962,319,363 төгрөгийн авлагын дунд нийт 352,361,971.45 төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулгын нөөц тооцсон.

3.4 Зээлийн эрсдэл

Компани санхүүгийн хэрэглүүрүүдийг хэрэглэх явцад зах зээлийн эрсдэл, үүнд үндсэн үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас үүдэн гарах гадаад валют, хүүгийн түвшин болон бусад үнийн эрсдэлтэй тулгардаг. Компани нь хэд хэдэн банканд мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулах замаар зээлийн эрсдэлд өртөхөөс хязгаарлагддаг байна.

Зээлийн эрсдэл нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс компанийд санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд үйлчлүүлэгчдээс авах авлагаас үүсдэг. Санхүүгийн хөрөнгө дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг. Компанийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэлийг хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

(төгрөгөөр)	2022	2023
Харилцах данс дахь мөнгөн хөрөнгө	2,012,949,577.26	752,423,020.79
Хадгаламж дахь мөнгөн хөрөнгө	500,000,000.00	1,199,900,000.00
Өрийн үнэт цаас	6,810,000,000.00	6,810,000,000.00
Дансны болон бусад авлага	1,055,265,860.47	1,169,307,702.11
Дүн	10,378,215,437.13	9,931,630,722.90

3.5 Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн бодлого нь зээлийн хүүгийн түвшний эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгах юм. Хадгаламж барьцаалсан зээл нь тогтмол хүйтэй бөгөөд компанийн төлж буй хүүгийн хэмжээ нь зах зээлийн эрсдэлд өртөх магадлал нь материаллаг бус байна.

3.6 Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь компани хүлээсэн үүргээ биелүүлж чадахгүй байх эрсдэл юм.

Компанийн бодлого нь үйл ажиллагааны болон зээлийн үйлчилгээтэй холбоотой төлбөрийг барагдуулахад хангалттай мөнгөн хөрөнгө болон түргэн борлогдох хөрөнгөтэй байх оновчтой хөрвөх чадварын удирдлагын бодлого хэрэгжүүлэх юм.

"Ди Би Эм ассет менежмент УЦК" ХХК
**4. 2023 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСВАР БОЛСОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
 ТОДРУУЛГА**

4.1. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2022	2023
Касс дахь мөнгө /төгрөг/	184,818.84	10,095.00
Харилцахад байгаа бэлэн мөнгө /Төрийн банк/	247,425,197.18	253,487,403.57
Харилцахад байгаа бэлэн мөнгө /Хаан банк/	150,000,000.00	24,000.00
Харилцахад байгаа бэлэн мөнгө /Төрийн сан /	300,743,847.24	13,980,933.84
Харилцахад байгаа бэлэн мөнгө (Хас банк)		299,990,000.00
Харилцахад байгаа бэлэн доллар /Төрийн сан /	1,464,780,532.84	734,954,683.38
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн	2,163,134,396.10	1,302,447,115.79

Тайлант онд компани нь Хас банк, Төрийн банкнд хадгаламж нээн байршиулсан байна.

4.2.a БУСАД АВЛАГА

	2022	2023
Хувь хүнээс авах авлага	162,533,021.21	145,043,615.59
	162,533,021.21	145,043,615.59

Татан буулгах комисст ажилласан 7 ажилтантай холбоотой 144,706,592 төгрөгийн авлагын улдэгдэл байна. Үнээс тайлант онд 14,593,408 төгрөгийн төлөлт хийгдээж авлага буурсан байна. Нэр бүхий 5 ажилтантай 2027 оны 07 дугаар сарын 30 дотор төлөхөөр эвлэрглийн гэрээ байгуулсан боловч, 2 ажилтан төлөлт хийгдээгүй байгаа нь эрсдэлтэй байна.

4.2.6 БУСАД АВЛАГА

Хүүний авлага

Хаан банк	320,547.94	24,192,000.02
Чингис хаан банк	248,132,897.47	248,132,897.47
Хас банк		369,850.69
Төрийн банк	394,520.54	443,835.61
Эрдэнэс таван толгой ХК	85,638,082.19	85,638,582.26
Хүүний авлагын дүн	334,486,048.14	358,777,166.05
Бусад авлага		
Чингис хаан банк	714,186,465.53	714,186,465.53
Ти Би групп ХХК	34,274,796.65	34,274,796.65
Азийн хөгжлийн банк	20,861,621.15	259,975,850.95
Нэгдсэн Үндэсний байгууллага		12,473,804.00
Бусад харилцагч	46,996.00	46,996.00
Бусад авлага	769,369,879.33	1,020,957,913.13
Найдвартай авлагын хасагдуулга	(211,123,088.21)	(355,470,992.66)
Авлагын цэвэр дүн	1,055,265,860.47	1,169,307,702.11

Санхүүгийн тайллангийн бусад авлагын дансанд бүртгэсэн 962,319,363 төгрөгийн авлага нь шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдсэн байна. Чингис хаан банктай холбоотой авлагын дунд өөрчлөлт ороогүй нь эргэлзээтэй байна. Тайлант онд 144,347,904.45 төгрөгийн найдвартай авлагын хасагдуулга нэмж тооцсон болно.

4.3. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА

ХХОАТ-ын авлага	311,666.67	311,666.67
ААНОАТ-ын авлага		
НӨАТ-ын авлага	14,040,099.15	17,189,945.88

НДШ-ийн авлага

	14,351,765.82	17,501,612.55
4.4. БУСАД САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ	2022	2023
Хугацаат хадгаламж /Төрийн банк/	250,000,000.00	300,000,000.00
Хугацаат хадгаламж /Хаан банк/	100,000,000.00	350,000,000.00
Богино хугацаат хөрөнгө оруулалт /Бонд/	6,810,000,000.00	6,810,000,000.00
	7,160,000,000.00	7,460,000,000.00

2023 оны 12-р сарын 31-нээрх бусад санхүүгийн хөрөнгийн дансанд нэг жилээс дээши хугацаагаар байршиулсан хугацаат хадгаламжийг бүртгэсэн болно. Мөн Эрдэнэс таван толгой ХК-ний бондыг бүртгэсэн байна.

4.5. БАРАА МАТЕРИАЛ

	2022	2023
Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарна	167,909.09	36,363.64
	167,909.09	36,363.64

4.6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

	2022	2023
Тээврийн хэрэгсэл	122,239,012.85	122,239,012.85
Тавилга эд хогшил	93,063,530.00	93,063,530.00
Компьютер бусад хэрэгсэл	69,441,645.08	69,441,645.08
Бусад үндсэн хөрөнгө	3,443,716.65	3,443,716.65
	288,187,904.58	288,187,904.58

ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ

	2022	2023
Тээврийн хэрэгсэл	75,573,353.27	75,573,353.27
Тавилга эд хогшил	46,159,091.48	55,459,842.80
Компьютер бусад хэрэгсэл	67,627,939.00	69,441,645.08
Бусад үндсэн хөрөнгө	1,698,801.75	2,042,953.18
	191,059,185.50	202,517,794.33

Тайлант онд шинээр үндсэн хөрөнгө бэлтгээгүй. Харин нийт 65,329,826.9 төгрөгийн 46 ширхэг компьютер, дагалдах хэрэгсэл, Iширхэг 27,027,846.18 төгрөгийн тээврийн хэрэгсэл нь элэгдлээрээ анхны ортгөө нохсон хөрөнгө байгааг, унийг шинэчлэн тогтоон бүртгэхээр байна.

4.7. ДАНСНЫ ӨГЛӨГ

Дансны өглөг

	2022	2023
Азийн хөгжлийн банк	1,464,780,532.80	734,954,683.38
Дансны бусад өглөг	425,239.66	215,485.63
	16,500.00	16,499.87
	1,464,797,032.80	734,971,183.25

Тус компани нь Азийн хөгжлийн банк болон Улаанбаатар хотын захиргаатай хамтран “Улаанбаатар хотын орлогод нийцсэн орон сууц ба дасан зохицох чадвар бүхий хотын шинэчилэл” төслийг 2019 оноос эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү төсөлтэй холбоотой санхүүжилтийн өглөг 215,485. мянган доллар буюу 794,954,683.38 төгрөгийг бүртгэн тайлагнасан.

4.8. ТАТВАРЫН ӨГЛӨГ

ХХОАТ-ын өглөг

НДШ-ын өглөг

Бусад татварын өглөг

	2022	2023
	122,000.00	68,458.07
		15,909.23
		13,980,933.84
	122,000.00	14,065,301.14

4.9. ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ

Энгийн хувьцаа /төрийн /

	2022	2023
	10,000,000,000.00	10,000,000,000.00
	10,000,000,000.00	10,000,000,000.00

Компани нь нэг бүр нь 200,00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 50,000 ширихэг энгийн хувьцаанаас бүрдэж байна. Тус компаний хувьцааг 100 хувь Монгол Улсын Хөгжлийн банк эзэмшиж байна.

4.10. ХУРИМТЛАГДСАН АШИГ

	2022	2023
Тайлант үеийн ашиг / алдагдал /	(601,768,309.80)	263,015,422.94
Өмнөх үеийн ашиг / алдагдал /	<u>(372,548,695.54)</u>	<u>(974,317,005.34)</u>
	<u>(974,317,005.34)</u>	<u>(711,301,582.40)</u>

2023 оны санхүүгийн орлогын дэлгэрэнгүй тайлангаар компани 263,015,422.94 төгрөгийн тайлант үеийн цэвэр ашигтай ажилласан.

4.11. ХҮҮНИЙ ОРЛОГО

	2022	2023
Хадгаламжийн хүүгийн орлого	794,520.54	100,519,575.40
Харилцахын хүүгийн орлого		1,313,318.53
Бондын хүүгийн орлого	149,260,273.97	681,000,000.00
	<u>150,054,794.51</u>	<u>782,832,893.93</u>

Компани тайлант онд хадгаламж болон харилцах дансны хүүгийн орлогоос 101,832,893.93 төгрөг олсон байгаа нь өмнөх үеэс 130 дахин өссөн бол бондын хүүгийн орлого 5 дахин нэмэгдсэн байна.

4.12. БОРЛУУЛАЛТ БА ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ЗАРДЛУУД

	2022	2023
Цалингийн зардал	197,957,124.21	239,990,132.97
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	24,728,231.42	29,947,930.27
Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	303,057.00	303,057.00
Бичиг хэргийн зардал	2,520,972.63	1,371,289.87
Шуудан холбооны зардал	2,510,279.83	1,863,979.52
Мэргэжлийн үйлчилгээний зардал	3,532,800.00	14,000,000.00
Сургалтын зардал	3,724,827.73	12,344,234.17
ТҮЗ-ын үйл ажиллагааны зардал		157,481.81
Даатгалын зардал	1,509,590.00	
Ашиглалтын зардал	342,571.89	
Засварын зардал	11,851,818.19	445,454.55
Элэгдэл, хорогдлын зардал	27,675,283.39	12,013,985.77
Түрээсийн зардал	71,605,090.88	3,654,545.46
Зохицуулалт үйлчилгээний зардал		1,000,000.00
Тээврийн зардал	154,000.00	
Түлш шатахууны зардал	3,151,558.38	
Зар сурталчилгааны зардал	409,090.91	1,629,272.72
Бусад зардал	2,200,134.98	1,712,500.00
Хангамжийн материалын зардал	224,954.54	6,352,459.10
Банкаар үйлчлүүлсний зардал		73,600.00
Бусад зардал		6,000.00
	<u>354,401,385.98</u>	<u>326,865,923.21</u>

4.13. БУСАД ОРЛОГО БА ОЛЗ

	2022	2023
Бусад орлого	687,260.00	31,154,510.00
Валютын арилжааны ашиг		9.54
Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		88,448,474.24
	<u>687,260.00</u>	<u>119,602,993.78</u>

Нэгдсэн Үндэсний Байгууллагатай хамтран "Ногоон санхүүжилтийн дундын санхүүжилтийн механизм"
судалгааны ажлыг хийж гүйцэтгэж 31,154,500 төгрөгийн бусад орлоготой ажилласан байна.

4.14. БУСАД ЗАРДАЛ БА ГАРЗ

	2022	2023
Торгууль алдангийн зардал		500,000.00
Хүлээн авалтын зардал		
Хандивийн зардал	500,000.00	
Найдвартгүй авлагын зардал	380,068,498.87	144,347,904.45
Нүүлгэлтийн зардал	2,035,000.00	
Бусад зардал	500,000.00	974,864.00
	<u>383,103,498.87</u>	<u>145,822,768.45</u>

4.15. ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН

ЗАРДАЛ

	2022	2023
Тайлант үеийн орлогын албан татварын зардал	15,005,479.45	78,283,289.33
	<u>15,005,479.45</u>	<u>78,283,289.33</u>

*Компани нь тайлант онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18 дугаар зүйлийн
18.6.3 т заасан хүүгийн орлоготой тул 10 хувиар татвар ногдуулсан байна.*

Аудитор

M. Эрдэнэжав

Ч.Эрдэнэжав

